



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 28 өдөр

Дугаар A/38

Батноров сум


Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ зохион байгуулахыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, өвөл, хаврын улиралд зохион байгуулагдах хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 нас хүртэлх хүүхдийг аливаа хэлбэрээр оролцуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Чимэгсүрэн), Цагдаагийн Хэсгийн төлөөлөгч (Г.Ганбаяр), Норовын хүлэг уяачдын холбооны тэргүүн (Г.Тайванжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийг хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Д.Бямбацогт)-д даалгасугай.



230425116